



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/197

Хэрлэн сум

Арга хэмжээ зохион байгуулж,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.1-ийн "а", Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.1, 7.6.2, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 02 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Байгаль орчны журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүднээс Хяналт шалгалт арга хэмжээг 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 14 хоногийн хугацаанд зохион байгуулж, үйл ажиллагааны зардалд 415800 төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх арга хэмжээний зардалд зарцуулах 415800 /дөрвөн зуун арван таван мянга найман зуун/ төгрөгийг аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Л.Бат-Октябрь/-д тус тус даалгасугай.

4. Хяналт шалгалт арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үр дүнтэй зохион явуулж, дүнг танилцуулахыг Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа О.Ганбат/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 987

Аймгийн Засаг даргын 2017 оны
05 дугаар сарын 24 өдрийн А/19.7
дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын зүйл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Бензин /80/	1500 км	1540	415800